



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН
ТЭЭВЭР ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.МӨНХТАМИР ТАНАА

2023.03.15 № 07/576
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд Компанийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монголын Иргэний Агаарын тээвэр ТӨХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх үүднээс "Карго тээвэрлэлт"-ийн B757-200 JU1109 маркийн онгоцыг Ирланд Улсын AQUILA AIR CAPITAL (IRELAND) DAC компанитай 5 жилийн хугацаатай түрээслэх гэрээг 2022 оны 7 дугаар сарын 23-ны өдөр байгуулж, 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглаж эхэлснээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчим болон СТОУС- 16 "Түрээс"-ийн дагуу түрээсийн зардал, түрээсийн өр төлбөрийг тайлант жилийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Монголын Иргэний Агаарын тээвэр ТӨХК нь санхүүгийн зорилгоор Агаарын хөлгийн ашиглах жилийг тогтоохдоо их биеийг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 6 дугаар хавсралтад заасан хугацааг баримтлан 22 жил, хөл ангийн хатуу цагтай эд ангийн хязгаар 10 жил, агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын зааврын дагуу хөдөлгүүрийн хатуу цагтай эд ангийн хязгаарыг 15000 цикл, туслах хөдөлгүүрийн хатуу цагтай эд ангийн хязгаарыг 20000 цикл байх заалтад үндэслэн хөдөлгүүр болон туслах хөдөлгүүрийн элэгдлийг бодит гүйцэтгэлээр тооцож, НББОУС 16-ын дагуу элэгдүүлдэг тул гол асуудал гэж үзсэн.

Ашигласан үзүүлэлт, удирдлагын таамаглалууд нь тохиромжгүй байж болзошгүй бөгөөд тооцооллын үр дүн материаллаг учир бид энэхүү тооцооллыг аудитын гол асуудалд оруулсан.

Бусад асуудлын хэсэг

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь тайлант онд Финайдиа ХХК-аар НББОУС 19 "Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж" стандартын дагуу ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн нөөц сангийн 26,343.6 сая төгрөгийн нөөц өр төлбөр, 10,835.2 сая төгрөгийн зардал, хуримтлагдсан ашиг 15,508.4 сая төгрөгөөр буурах актаур тооцооллыг хийлгэсэн байна.

Гэвч тус компанийн үндсэн үйл ажиллагааны орлогыг бууруулж, бизнесийн гадаад, дотоодын хамтын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэй байсан тул удирдлага дахин боломжит хувилбарыг судлах үүднээс тайлант жилийн Санхүүгийн тайланд толилуулаагүй байна.

Бусад мэдээлэл

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК компани 2022 онд нийтдээ 1623 нислэгийг үйлдсэн ба үүнд 895 хуваарьт нислэг, 562 захиалгат нислэг, 152 карго нислэг, 14 удаагийн бусад нислэгийг үйлдсэн байна. Монгол Улс нь 39 улстай агаарын харилцааны хэлэлцээртэйгээс, Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК Ази болон Европ тивийн 8 улс, 10 хот руу (Франкфурт, Токио, Сөүл, Пусан, Бээжин, Гуанжоу, Банконг, ХонгКонг, Истанбул) хуваарьт тогтмол нислэг үйлдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ